



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 09 ёдэр

Дугаар A/154

Улаанбаатар хот

Цагийн хөлсний хэмжээ, олгох
журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүнд олгох цагийн хөлсний хэмжээг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн турван талт үндэсний хорооноос баталсан тухайн онд мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний нэг цагийн доод хэмжээг дөрөв дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоосугай.

2. Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн гишүүнд цагийн хөлс олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т, цагийн хөлс олгох зардлын хэмжээг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Л.Мөнхзул/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Х.БУЛГАНТУЯА



151230426

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/153 дугаар тушаалын хавсралт

**МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮНД ЦАГИЙН ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 42 дугаар зүйлийн 42.10 дахь хэсэгт заасан маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөл болон салбар зөвлөл (цаашид “зөвлөл” гэх)-ийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хуралд оролцсон цагийг харгалзан цагийн хөлс олгоход энэхүү журмыг баримтална.

Хоёр. Цагийн хөлс олгох

2.1. Зөвлөлийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хуралд оролцсон цагийг харгалзан баталсан хэмжээгээр хөлс олгоно.

2.2. Энэ журмын 2.1-д заасан хөлсийг цагаар тооцож олгох бөгөөд гишүүдийн хуралд оролцсон нийт цагийг бүртгэх, гишүүдэд цагийн хөлс олгох, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах, холбогдох тайлан гаргах үйл ажиллагааг зөвлөлийн нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ.

2.3. Цагийн хөлсийг зөвлөлийн гишүүдийн хуралд оролцсон цагийн нотлох баримтад тулгуурлан олгож байгаа эсэхэд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Зөвлөлийн дарга тус тус хяналт тавьж ажиллана.

2.4. Зөвлөлийн гишүүдийн цагийн бүртгэл олон нийтэд нээлттэй байна.

Гурав. Бусад

3.1. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---Оо---